

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр

№	Хийсэн ажил /чиглэлээр/	Гүйцэтгэсэн ажлын төрөл дараахь 4-н аль нэгийг сонгож (✓) тэмдэглэгээ хийх			
		Тулгамд- сан ажил	УИХ, ЗГ- т өргөн барьсан	Салбарын хүрээнд хийгдсэн	Шинэлэ г ажил
I	Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр				
1.	Нийгмийн даатгалын багц хуулийн төсөлд МАН-ын дэргэдэх судалгааны хүрээлэнгүүд дүн шинжилгээ хийсэн бөгөөд 10 дугаар сарын 05-ны өдөр ХНХЯ-ны удирдлага, холбогдох мэргэжилтнүүд, судалгааны багийн гишүүд оролцсон багц хуулийн төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулав. Хэлэлцүүлгийн үеэр хуулийн төсөлд өгсөн санал, тулгамдаж буй асуудал холбогдох тооцоо судалгаануудыг танилцуулав.		✓		
2.	МАН-ын дэргэдэх судалгааны хүрээлэнгүүдтэй 10 дугаар сарын 12-ны өдөр дахин уулзалт хийж холбогдох тооцоо мэдээллийг танилцуулж, ирүүлсэн саналуудыг судлан үзэж, боломжтой саналыг тусган ажиллав.		✓		
3.	Монгол Улсын Засгийн газраас энэ оны 7 дугаар сард УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангалаа. Хөтөлбөрийг ЭЗБХ-ны хурлаар хэлэлцээд УИХ-ын Нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн болно.		✓		
4.	2023 оны төсвийн тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэж байгаатай холбоотой Нийгмийн халамжийн сангийн 2023 оны төсөвтэй холбоотой УИХ-ын гишүүдээс асууж болзошгүй асуултуудад хариулт бэлтгэн сайд, удирдлагуудад танилцуулав. Мөн Дэлхийн 16 орны хүүхдийн мөнгөн тэтгэмж олгож байгаа туршлагын талаар мэдээлэл бэлтгэх, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн 2012 оноос хойших хэрэгжилтийн талаар мэдээлэл бэлтгэв.		✓		
5.	2023 оны төсвийн төсөлд холбогдох мэдээлэл, танилцуулга /тэтгэвэр тооцох цалингийн итгэлцүүр, нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох дэмжлэг, сангийн орлого, зарлага, яамны холбогдох бусад мэдээлэл/-ыг бэлтгэн яамны удирдлагууд болон Сангийн яаманд танилцуулав.		✓		
6.	Монгол Улсын онцлогт нийцсэн Хуримтлалын нэгдсэн сангийн тогтолцоог бий болгох чиглэлээр 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан санамж бичгийн хүрээнд Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын зөвлөх үйлчилгээний багаас эхний шатны ажлын тайланг хүлээн авч, 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр тайланг хэлэлцэх цахим хурлыг зохион байгуулав. Уг хуралд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, ажлын хэсгийн гишүүд, Сингапурын зөвлөх үйлчилгээний багийн гишүүд оролцов.			✓	
7.	Засгийн газрын 2021 оны 362 дугаар тогтоолоор батлагдсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам”-ын хэрэгжилтэд хяналт тавих, сайжруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор аймаг дүүргийн хэлтсүүдээс санал авах загвар боловсруулан хүргүүлээд байна.			✓	
8.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор Засгийн газар тогтооно” гэж заасны дагуу “Монгол Улсад 2023 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны		✓		

	тоо, хувь хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 359 дүгээр тогтоолыг батлуулав.				
9.	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг төрийн байгууллагууд, шүүх цагдаа прокурор, нотариат, өмгөөллийн байгууллагын төлөөллөөр хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлгийг ХЗДХЯ-тай хамтран зохион байгуулсан. Яамнаас холбогдох мэдээллийг бэлтгэж танилцуулсан. 11 дүгээр сард олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулна.			√	
10.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 20 орчим удаа хэлэлцүүлж, Засгийн газрын гишүүдээс санал авч сайжруулсан. Засгийн газрын бүрэлдэхүүн шинэчлэгдсэн тул хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг дахин шинэчилж, хянагдаж байна.			√	
11.	“Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам”-ын төслийг боловсруулан, СЯ, ХЗДХЯ, ЭМЯ болон цахим хэлбэрээр үндэсний хэмжээнд хэлэлцүүлж, шаардлагатай саналыг тусган, төслийг эцэслэсэн. Журмын төслийг ХЗДХЯ, ЭМЯ-нд хамтарсан тушаалаар батлуулахаар ХНХ-ын дэд сайдын 2022 оны 3/2497 албан тоотой хүргүүлээд байна.			√	
12.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасан “Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам” ХНХ-ын сайд, ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/173, А/120 дугаар хамтарсан тушаалаар батлагдан хэрэгжиж байна. Тус журмыг шинэчлэн батлуулахаар төслийг боловсруулан ХЗДХЯ-нд хүргүүлэхэд бэлтгэв.			√	
13.	“Хүүхдийн зусланд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төслийг өмчийн хэлбэр харгалзахгүй санхүүжүүлэх журам”-ын төслийг эцэслэн боловсруулж, санал авахад бэлтгэв.			√	
14.	“Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлуулах ажлын хүрээнд БШУЯ, БТСУХ, Монголын ой тогтоолтын холбоотой уулзалт зохион байгуулж, тэдний саналыг тусгав.			√	
15.	Хүүхэд харах үйлчилгээний шалгуур, болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам, эцэг эх асран хамгаалагчаас төлөх төлбөрийн дээд хэмжээг ХНХ-ын сайдын А/180 дугаар тушаалаар шинэчлэн баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2022 оны 10 сарын 13 нд бүртгүүлэв.			√	
16.	<ul style="list-style-type: none"> Дотоодын хууль тогтоомжийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын зүйл, заалт, зөвлөмжид нийцүүлэх талаар санал боловсруулав. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт тусгагдсан эрх зүйн орчныг сайжруулах санал, зөвлөмж боловсруулах дэд ажлын хэсгийн хүрээнд зөвлөх үйлчилгээ авах ажлын санал, төлөвлөгөөг боловсруулж байна. Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төсөлд зардлын тооцоолол хийх жагсаалтыг боловсруулж зөвлөхөд хүргүүлээ. “Иргэдийг төрийн өмчийн түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын төсөлд холбогдох чиглэлээр санал боловсруулан хүргүүлээ. 			√	
II	Бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр				
17.	Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн хүрээнд Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлтэй холбоотой тооцоо судалгааг хийлгэхээр олон улсын зөвлөх, актуарч Кеннет Доналдсон болон Маттиас Зийб нартай хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд холбогдох тоон мэдээлэл,			√	

	судалгааг НДЕГ, НДЕГ-ын дэргэдэх Мэдээллийн технологийн төв болон бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж 30 гаруй тооцоо судалгааг хүргүүлээд байна.				
18.	Нийгмийн даатгалын өнөөгийн нөхцөл байдал, тогтолцоотой холбоотой нэвтрүүлэг бэлтгэж байгаа бөгөөд энэ хүрээнд SBN телевиз болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж байна.			√	
19.	Азийн Хөгжлийн Банк, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын улаан загалмай нийгэмлэгийн хамтран “ТӨГСӨЛТИЙН АРГАЧЛАЛААР” туршилтын хөтөлбөрийг Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү ажлын хүрээнд “Монголын улаан загалмай нийгэмлэг” нийт сонгогдсон дүүргийн 35 коуч, нийгмийн халамжийн хороодын мэргэжилтнүүдийг хамруулсан сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 25, 27-ны өдөр зохион байгуулав.			√	
20.	“Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын төсөл”-ийг хэрэгжүүлэх баг, ХНХЯ, АХБ-ны төслийн нэгжийн хамтарсан уулзалтыг 2022 оны 10 дугаар сарын 17, 30-ны өдрүүдэд зохион байгуулж, төслийн цаашдын төлөвлөгөө, төсөв, үр нөлөөний үнэлгээ, анхаарах асуудлууд болон зарим удаашралтай ажлуудыг хэрэгжүүлэхэд хамтын ажиллагааг шуурхай болгох талаар санал солилцож ажиллав.			√	
21.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар Азийн хөгжлийн банкны (АХБ) техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын төсөл”-д 1520 өрхийг сонгоход тавигдаж байгаа нэг шалгуур бол өмнө нь амьжиргааг дэмжих ижил төрлийн хөтөлбөрт хамрагдаагүй байх шаардлагын дагуу Дэлхийн Зөн Монгол ОУБ-д 10 дугаар сарын 07-ны өдрийн 3/2584 албан бичгээр хүргүүлж, Төгсөлтийн аргачлал хөтөлбөрт 2019-2023 оны эцэс гэхэд хамрагдаад төгссөн болон одоо хамрагдаж байгаа өрхүүдийн мэдээллийг авлаа. Мэдээллийг хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлж өрхийн давхардлыг арилгав.			√	
22.	Ядуурлыг бууруулах талаар санал боловсруулж, яамны удирдлагуудад танилцуулах ажлыг зохион байгуулж байна. Энэ хүрээнд Ядуурлыг бууруулах үндэсний зөвлөл байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулаад байна.			√	
23.	Монгол Улсын Засгийн газрын түвшинд шийдвэрлэх шаардлагатай богино хугацаанд үр дүн гарах боломжтой төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг бэлтгэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 02/2595 албан тоотоор хүргүүлэв.			√	
24.	Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх, төрөлжсөн асрамжийн газруудын үйл ажиллагаатай танилцах Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын хэсэг, түүнд дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсэг байгуулагдан 2022 оны эхний хагас жилийн турш ажилласан. Энэ хүрээнд Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 6 сарын 7-ны өдрийн “Чиглэл өгөх тухай” 14 дүгээр тогтоолыг баталсан. Уг тогтоолын хэрэгжилтийн явцыг Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанд танилцуулсан бөгөөд хуралдаанд Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, яамны болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын холбогдох удирдлагууд оролцов. Уг тогтоолд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, харьяа байгууллагатай холбоотой 9 заалтын хэрэгжилт биелэлтийг Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр дэлгэрэнгүй танилцуулж, гишүүдийн асуултад хариулт өгч, цаашид 2023 оны 2 дугаар сард тайланг өгөх хүртэл зарим арга хэмжээг эрчимжүүлэхэд анхаарч, төлөвлөгөө гарган ажиллахаар болов.			√	
25.	“Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны “Чиглэл өгөх тухай” 14 дүгээр тогтоолын хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 10 сарын 21-ний өдрийн А/212 дугаар тушаалаар			√	

	батлуулан яамны холбогдох газар, харьяа байгууллагад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.				
26.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/05 дугаар тушаалаар байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд нийгмийн халамжийг зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцүүлж, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглүүлэх, үйлчилгээний нэр төрлийг оновчтой тогтоох, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд санал, дүгнэлт боловсруулан танилцуулах үүрэг бүхий салбар дундын ажлын хэсгийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааны тайлан, нэгдсэн санал, дүгнэлтийг боловсруулав.			√	
27.	Нийслэлийн 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст 2022 оны 10 дугаар сарын 12-17-ны өдрүүдэд нийгмийн халамжийн үйлчилгээг гардан хүргэж байгаа албан хаагчид, зарим хороодын хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн ажил байдал, "ehalamj.mn"- цахим системээр үзүүлж байгаа үйлчилгээний хэрэгжилтийн явц, тулгамдаж буй асуудалтай газар дээр нь танилцаж, шийдвэрлэх арга зам, ажил сайжруулах талаар зөвлөгөө чиглэл өгөв.			√	
28.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй уялдуулан Засгийн газрын "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 2022 оны 338 дугаар тогтоол батлагдан хэрэгжиж байна. Засгийн газрын тогтоолын дагуу Хөдөлмөрийн сайд болон Сангийн сайдын 2015 оны "Гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээний журам, хураамжийн хэмжээ батлах тухай" А/108/149 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүй болгох хамтарсан тушаалыг батлууллаа.			√	
29.	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/162 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тооцоо, судалгаа бусад баримт бичгийн хамт боловсруулах ажил хийгдэж байна. Ажлын хэсгийн гишүүдээс боловсруулсан хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад 2022 оны 01 дүгээр сард 01/219 тоот, 07 дугаар сард 01/1861 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. ХЗДХ-ийн сайдаас 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 01/3652 тоот албан бичигт "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг "Шинэ сэргэлтийн бодлого"-той нийцүүлэх хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийн эх үүсвэр нь голчлон гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний ажлын байрны төлбөрийн орлогоос хамааралтай байгааг өөрчилж, санг илүү тогтвортой эх үүсвэрээс бүрдүүлэх чиглэлд санал ирүүлсэнийг, үзэл баримтлалын төслийн 1.2 дугаар хэсгийн 5-д болон 3 дугаар хэсгийн 4-т тус тус тодорхой тусгаж ХНХ-ын сайдаар батлуулан, Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлэхээр ажиллаж байна.			√	
30.	Дэлхийн банкны санхүүжилтээр Монгол Улсын Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэх Ejob платформыг нэвтрүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/126 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж байна. Ejob платформ нь 6 дэд систем 20 модулиас бүрдэх бөгөөд программ хөгжүүлэлтийн ажлыг 2022 оны 02 дугаар сараас эхлүүлсэн. 2022 оны 10 дугаар сарын байдлаар ажлын хэсэг 13 удаа, системийн дизайн хөгжүүлэлтэд санал өгөх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний процессын зураглалыг шинэчлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсэг 8 удаа, шаардлагатай бусад уулзалт хэлэлцүүлгийг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна.			√	

	<p>Дэлхийн банкны IT зөвлөх Ashish Joshi 2022 оны 03, 09 дүгээр сард манай улсад айлчлал хийн ажиллах үеэр тус системийн хөгжүүлэлтийн явцыг төлөвлөгөөний дагуу амжилттай хийгдэж байгааг сайшаан онцолж, цаашид эрчимжүүлэх ажилд чиглэл, санал зөвлөмжийг өгөн оролцогч талуудад хүргүүлээд байна. Одоогийн байдлаар системийн хөгжүүлэлт, модулиудын хөгжүүлэлтийн ажлууд 80%, төслийн нийт гүйцэтгэл 90%-тай байна.</p> <p>Еjob платформыг 2022 оны 11 дүгээр сард нэвтрүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 21 аймаг, 9 дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл хангаж байна.</p>				
31.	"Журамд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2022 оны 80 дугаар тогтоолын дагуу аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлж эхлээд байна. Тайлант хугацаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/156 дугаар тушаалаар нийт 65 аж ахуйн нэгж, байгууллагын 419 гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлөв.			√	
32.	Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарыг чадавхижуулах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, удирдамжийг ЗГХА-ГБХЗХГ-тай хамтран боловсруулж, хөрөнгийн тооцоог хийж, холбогдох газарт санхүүжилтийн асуудлыг шийдүүлэхээр уламжлав.			√	
33.	Гэр бүлд чиглэсэн хууль эрх зүйн орчинг сайжруулж, хүүхэд, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагын заавар, гэр бүлд үзүүлэх нийгмийн ажил, үйлчилгээний хувилбар, арга зүй боловсруулах ажлыг гүйцэтгэх 3 зөвлөхтэй гэрээ байгуулав.			√	
34.	Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрнаас үзүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй болгоход чиглэсэн нийгмийн ажилтны албан хэрэгцээнд зориулсан удирдамжийн төсөл боловсруулж, ХНХ-ын сайдын тушаалаар батлахад бэлтгэв.			√	
35.	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 10 дугаар тайлангийн зөвлөмжийн орчуулгыг бэлтгэв. Монгол Улсын Засгийн газар "Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай" конвенцийн хэрэгжилтийн талаарх ээлжит 10 дугаар тайланг НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах Хорооны 82 дугаар хуралдаанаар амжилттай хэлэлцүүлсэн ба Хорооноос Монгол Улсад ирүүлсэн зөвлөмжийн төслийг орчуулан, зөвлөмжийг хэрэгжүүлэх салбар дундын ажлын хэсгийг байгуулахаар холбогдох яамд байгууллагууд руу албан тоот хүргүүлж, нэрсийг аваад байна. Ажлын хэсгийн тушаалыг ХНХ-ын сайдын тушаалаар батлуулна.			√	
36.	Хүүхэд, залуучуудын статистикийн үзүүлэлт тооцох аргачлалыг ҮСХ-ны даргын 2022 оны 10 дугаар сарын 20-ны А/172 дугаар тушаалаар батлуулав.			√	
37.	Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн "Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай" 2018 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд харьяа байгууллагуудын Хүүхэд хамгааллын бодлого, эцэг эхийн зөвлөл болон байгууллагын дэргэдэх цэцэрлэг, хүүхдийн өрөөний судалгааг гаргав.			√	
38.	ХНХЯ-ны төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Хүүхэд харах үйлчилгээний хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ, хэрэгцээ тодорхойлох судалгаа хийж ажлын удирдамж боловсруулж холбогдох стандарт эрх зүйн баримт бичиг боловсруулах зөвлөх багтай хамтран ажиллаж байна.			√	
39.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/172 тушаалаар Жендэрийн салбар зөвлөлийг шинэчлэн батлаж, харьяа газруудад дэд салбар зөвлөл байгуулах чиглэл хүргүүлэв.			√	

40.	“Хүн ам, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарт баримтлах жөндөрийн бодлого 2018-2024” стратегийн бодлого хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхээр төлөвлөгөө боловсруулан ЖҮХорооны шинжээчдийн бүлгээс бүрдсэн багтай хамтран ажиллаж байна.			√	
41.	<ul style="list-style-type: none"> Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх, эрх оролцоог нь хангах чиглэлээр харъяа байгууллагуудад хүргүүлэх ерөнхий чиглэлийн санал боловсрууллаа. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооноос ойрын болон дунд хугацаанд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж, хүргүүллээ. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 4.6.6-д байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцсэн тусгайлсан ажлын байрыг шинээр бий болгож турших, ажлын даалгаварт санал боловсруулж, ХБХХЕГ-т хүргүүллээ. Үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн маягт боловсруулахад шаардлагатай холбогдох мэдээллийг бэлтгэв. 			√	
42.	<ul style="list-style-type: none"> Манай яам Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 149 дүгээр сургуультай хамтран хэрэгжүүлсэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй сургуулийн загвар төсөл”-ийг бусад сургууль дээр үргэлжлүүлэн хэрэгжүүлэх саналыг БШУЯ-нд хүргүүллээ. АХБ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Монгол улс дахь тэгш хүртээмжтэй боловсрол, боловсролын технологийн хүртээмж төсөл”-ийн хүрээнд боловсролын технологийн (EdTech) хэрэглээний өнөөгийн нөхцөл байдал, технологи Монгол улс дахь хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нарт боловсрол эзэмшихэд нь дэмжлэг үзүүлж буй цар хүрээг тодорхойлох зорилготой “Тэгш хүртээмжтэй боловсрол, боловсролын технологийн хүртээмж” сэдэвт асуулгын хариултыг бэлтгэлээ. 			√	
43.	<ul style="list-style-type: none"> ХНХЯ болон Азийн хөгжлийн банкны төлөөлөгчид Дархан-Уул, Сэлэнгэ аймагт 2022 оны 10 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд ажиллаж, Идэвхитэй насжилтыг дэмжих төвийн үйл ажиллагаатай танилцаж, орон нутгийн Төслийн Удирдах хорооны ээлжит хуралд оролцон, төслийн хэрэгжилт, тулгамдсан асуудал болон салбар дундын уялдааг хангахад чиглэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллалаа. ХНХЯ, АХБ, олон улсын зөвлөхүүдтэй хамтран 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр “Ахмад настны урт хугацааны тусламж үйлчилгээний шинэлэг тогтолцоог хөгжүүлэх нь” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа. 			√	
44.	<ul style="list-style-type: none"> “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх салбар дундын хэлэлцүүлэг”-т оролцож, холбогдох мэдээллийг хүргэлээ. И-Монголиа-д нэвтрүүлэх үйлчилгээний саналыг боловсрууллаа. 			√	
45.	Саадгүй байдал, хүртээмжийн үнэлгээ хийх ажлын хэсгийг 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/190 дугаар тушаалаар батлуулж, ажлын хэсгийн хурлыг зохион байгууллаа.			√	
III	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр				
46.	Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалтыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын үүрэг хариуцагчийн 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/184 тоот тушаалаар батлуулав. Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалтыг 2022 оны 11 дүгээр сарын 15-20-ны өдрүүдэд зохион байгуулна.			√	
47.	“Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар			√	

	ирүүлсэн саналыг судлах чиглэл бүхий ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 10 дугаар сарын 10-ны А/187 дугаар тушаалаар байгуулав.				
48.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын тогтолцоог боловсронгуй болгохтой холбогдуулан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/183 дугаар тушаалаар байгуулж, ажлын хэсгийн эхний хурлыг 2022.10.07-ны өдөр зохион байгуулав.			√	
49.	“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.5.6 дахь зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тэтгэвэр тогтоолтын хуудсыг цахимжуулж, Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia)-ээс лавлагаа байдлаар цахимаар авах боломжийг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бүрдүүлэв.			√	
50.	Нийгмийн даатгалын 4 сангийн 2022 оны 9 дүгээр сарын мөнгөн урсгалын тайланг гарган, удирдлагуудад танилцуулав. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж хэвийн олгогдож байна.			√	
51.	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах, шалгалт авах журам”-ын дагуу ХАБЭА-ын сургагч багш нарыг бэлтгэх ажлын хүрээнд мэргэжлийн холбоод, Төрийн бус байгууллага, их дээд сургуулийн багш, эрдэмтэдтэй хамтран 2022 оны 9 дүгээр сарын 19-нөөс 24-ний хооронд 29 сургагч багшийг бэлтгэсэн бөгөөд 10 дугаар сард дахин 30 багшийг сургалтад хамруулав.			√	
52.	“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх 2022 оны арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх хүрээнд Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн багц стандартыг шинэчлэх ажлыг тус яамнаас холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр хэлэлцүүлэг зохион байгуулав.			√	
53.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хуулийн дагуу даатгуулагчид тэтгэвэр тогтоож, олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч байгаа зөрчлийг арилгах, Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулав.			√	
54.	Эрүүл мэндийн яам нь “Нip” программыг салбарын хэмжээнд нэвтрүүлэх гэж байгаатай холбогдуулан 2 сайдын хамтарсан тушаалаар Нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай салбар хоорондын мэдээлэл солилцох аргачлалыг тодорхойлох ажлын хэсгийг байгуулах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын төсөл, удирдамжийг боловсруулан ажиллаж байна.			√	
55.	Халамжийн үйлчилгээний хэрэгжилтийг сайжруулах асуудлаар ХХҮЕГ, НХХҮГ болон БЗД-ийн ХХҮХ-ийн удирдлага ажилтнуудтай цахим уулзалт хийж, холбогдох чиглэлээр Дэд сайд С.Зулпхар үүрэг даалгавар өгөв.			√	
56.	Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн давхардлыг арилгах, хамрагдаж буй үйлчилгээний тоо, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн судалгааг хүн амын бүлгээр нь, аймаг дүүргээр нь тус тус гаргаж удирдлагуудад танилцууллаа. Түүнчлэн УИХ, Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдэд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн талаар тодорхой мэдээлэл өгөх зорилгоор үйлчилгээ тус бүрээр 20 кейс бүхий танилцуулга бэлтгэв.			√	
57.	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд нийслэлийн хэмжээнд гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Нийгмийн			√	

	хамгааллын тусгай төв болон түр хоноглох үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэж байгаа байгууллагуудад 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр очиж ажиллав.				
58.	Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, халамжийн үйлчилгээний хамрах хүрээг оновчтой тодорхойлох, халамжийн сангийн төсөв, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зорилгоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт чиглэл хүргүүлэв.			√	
59.	Азийн хөгжлийн банкны “Цар тахлын үед хариу хариу арга хэмжээ авах нийгмийн хамгаалал төсөл-2”-ийн хүрээнд хэрэгжиж буй “Төгсөлтийн аргачлал буюу ядуурлыг төгсгөх хөтөлбөрийн туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлж байгаатай холбогдуулан “Нийгмийн хамгааллын тулгуур багана” сэдэвт сургалтыг Сонгинохайрхан, Баянзүрх болон Чингэлтэй дүүргийн холбогдох хороодын нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулан 2022 оны 10 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд зохион байгуулав.			√	
60.	2023 онд төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх 6 арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан тооцоо, судалгаа хийж, нэмэлт, өөрчлөлт оруулах дүрэм, журмын төслүүдийг боловсруулав.			√	
61.	Төрийн захиргааны албан тушаалын 15 ангилал, зэрэглэлийг 10 болгон нягтаршуулах Засгийн газрын тогтоолын төслийн талаар танилцуулга бэлтгэн Төрийн албаны зөвлөлийн холбогдох албан тушаалтнуудад танилцуулав.			√	
62.	“Хөдөлмөрийн сонирхлын маргааныг хөдөлмөрийн зуучлагчийн дэмжлэгтэйгээр зохицуулах журам”, “Хөдөлмөрийн арбитрын дүрэм”-ийг батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч нэгтгэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгов. “Хөдөлмөрийн арбитрын дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2001 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 55 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцохоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан, үзэл баримтлалын төслийг батлуулахаар ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Ерөнхий сайдын 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 169 дүгээр захирамжаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар шинээр томилогдсонтой холбогдуулан Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг батлан дахин хүргүүлэв.			√	
63.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/164 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор 2022 оны 10 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, олборлох салбарын ажил олгогч, туслан гүйцэтгэгч компаниудын төлөөлөл, ажилтны төлөөлөлтэй уулзалт ярилцлага хийн, мэдээлэл хүргэн, уртын ээлжийн горимын хэрэгжилтийн нөхцөл байдалтай танилцлаа. Тухайлбал: Эрдэнэс Таван Толгой ХК, Энержи Ресурс ХХК, Оюу Толгой ХХК тэдгээрийн туслан гүйцэтгэгч Монгол Майнинг энд Эксплорейшн ХХК, Хишиг Арвин Индустриал ХХК, Ти Ти Жи Ви Си Өү ХХК, Нормант ХХК, Си Ар 19 ХХК, Эр Майнинг ХХК, Мэра ХХК, Уорли Инженеринг ХХК.			√	
64.	ЗГХЭГ-ын дарга, Монгол Улсын сайд Д.Амарбаясгалангийн баталсан удирдамжийн дагуу “Өргөө амаржих газар” төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт Хөдөлмөрийн хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжилтийг шалгасан болно. “Өргөө амаржих газар” төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгийн хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцийн томилгоо, сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ч.Янжинхорлоо 2022 оны 10 дугаар сарын 17-наас 10 дугаар сарын 31-ний өдрүүдэд хяналт, шинжилгээг хийж гүйцэтгэсэн болно.			√	

65.	Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүдийн тоон мэдээллийг нэгтгэн 2022 оны 1,2 дугаар улирал, 2022 оны 09 сарын байдлаар гаргаж, www.mlsp.mn сайтад байршуулав.			√	
66.	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг 2022 онд зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/47 дугаар тушаалаар байгуулав. Төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Батлан хамгаалахын сайд нараар 2022 оны 03 сарын 22-ны өдөр батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төслийн хүрээнд нийт 4 ээлжээр 1231 залуус төсөлд хамрагдсан. Үүний 740 эмэгтэй, 491 эрэгтэй байсан бол нийт залуусын 725 (61%) 18-25 насны, 321(27%) 25-30 насны, 158 (12%) 30-34 насны залуус хамрагдаад байна.			√	
67.	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан шинэчилсэн хуулийн хүрээнд Монгол Улсын иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжүүдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. Хуулийн шаардлагын дагуу 36 байгууллагын материал хүлээн авсан байна.			√	
68.	НҮБ-ын хүүхдийн сантай хамтран Гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын асуудлаар Гамшгийн 5 төрлөөр удирдамж боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ хийн ажиллаж байна.			√	
69.	Хүүхдийн хөгжил, хамгааллын салбар дундын ажлын хэсгийн хурал зохион байгуулж, салбаруудын хүүхэд хамгааллын бодлогын төслийг хэлэлцүүлж, Эрүүл мэндийн яам, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс “Хүүхдийн хорт хавдрын хожуу оношлогдож байгаа тохиолдол” Хүүхэд, өсвөр үеийнхний тусламж, үйлчилгээний зураглал сэдвээр илтгэл танилцуулсан. Хурлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам хамтран хорт хавдартай хүүхдийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох бодлогын шинжилгээ хийж, судалгаа, шинжилгээнд үндэслэн хууль, эрх зүйн орчны шинэчлэл, үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэлээ.			√	
70.	Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам хамтран Боловсролын орчин дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын судалгааг 2022-2023 оны хичээлийн жилд сургуульд суурилан зохион байгуулахаар бэлтгэл ажлыг эхлүүлэв.				√
71.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 163 дугаар захирамжаар “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа болон өрх, иргэний талаарх төрд байгаа мэдээлэлд тулгуурлан өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журам болон өрх, хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Энэ хүрээнд ХНХ-ын сайдын 2022 оны А/189 дугаар тушаалаар төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохион байгуулах, програм хангамж хөгжүүлэх болон Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал, хэрэгжүүлэх журмын төслийг боловсруулах чиг үүрэг бүхий 2 дэд ажлын хэсгийг байгуулж, ҮСХ, ХНХЯ, СЯ, ЦХХХЯ, Монгол банк зэрэг холбогдох байгууллагууд хамтран ажиллаж байна. Дараах ажлууд хийгдээд байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • “Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал, хэрэгжүүлэх журмын төсөл боловсруулах” дэд ажлын хэсэг хуралдаж, шаардлагатай мэдээллийн хүрээг тодорхойлох, ойлголт, тодорхойлолт, талбарыг боловсруулсан. • Тооцоолол, аргачлалын төсөл боловсруулахад зөвлөх авахаар Дэлхийн банкны холбогдох албан хаагчидтай уулзалт хийсэн. 			√	

	<ul style="list-style-type: none"> “Төрийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохион байгуулах, програм хангамж хөгжүүлэх” дэд ажлын хэсгийн хурлыг зохион байгуулав Ажлын хэсгийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу мэдээлэл аргачлал боловсруулахад шаардагдах мэдээллийг цуглуулах, солилцох ажлыг зохион байгуулж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтаагүй ч мэдээлэл авах шаардлагатай байгаа Хил хамгаалах ерөнхий газар болон Орон сууц нийтийн аж ахуйн газарт авах шаардлагатай байгаа мэдээллийн талаар дэмжлэг хүссэн албан бичиг хүргүүлэв. <p>Ажлын хэсгээс мэдээлэл солилцох үйл ажиллагаанд Тагнуулын ерөнхий газрын дэмжлэг зайлшгүй шаардлагатай гэсэн тул тус газарт дэмжлэг хүссэн албан бичгийг хүргүүлэв.</p>				
72.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний А/107 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн холбогдох албан хаагчид Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтад очиж салбарын бүртгэл, статистик болон мэдээллийн сангийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх, зөвлөн туслах, чиглүүлэх, харилцан туршлага солилцох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохоор ажиллаж, тайлангийн төслийг боловсруулаад байна.			√	
73.	Нийгмийн халамжийн статистикийн тайлан маягт шинэчлэхээр яамны болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын халамж хариуцсан албан хаагчидтай 2 удаа уулзалт зохион байгуулж, маягт, тайланг хэрхэн шинэчлэх талаар хэлэлцэж маягтын эхний төслийг боловсруулаад байна.			√	
74.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 02/2715 дугаар бичгээр нийгмийн халамжийн статистик тайлан мэдээний тооцох аргачлал буруу, тоо мэдээлэл зөрүүтэй гарч байгааг яаралтай арга хэмжээ авч ажиллах чиглэл өгсөн. Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн аж ахуй, нэгж байгууллагын сарын дундаж цалингийн тайлан маягтыг мөрдүүлэх хугацааг хойшлуулах талаар Нийгмийн даатгалын ерөнхий газраас албан бичиг ирсэнийг Үндэсний статистикийн хороонд хүргүүлэхээр бэлтгэж байна. Мөн Үндэсний статистикийн хорооноос дундаж цалингийн 2022 оны 1,2 дугаар улирлын байдлаар өндөр утгыг хасаагүй мэдээллийг хүссэн бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Мэдээллийн технологийн төвөөс гаргуулахаар холбогдож ажиллаж байна.			√	
75.	Үндэсний статистикийн хороо, яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, ЗГХА-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, НҮБ-ын хүүхдийн сантай хамтран хүүхдийн эрх, хамгааллын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал, танилцуулга бэлтгэж статистикт хүргүүлсэн. Үндэсний статистикийн хорооны Аргазүйн байнгын зөвлөл болон Даргын зөвлөлийн Үндэсний статистикийн хорооны 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/172 тоот тушаалаар батлуулсан. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас боловсруулсан хүүхдийн статистикийн бүртгэлийн болон захиргааны тайлангийн маягтаар 3 удаа уулзаж, санал зөвлөмж өгсөн.			√	
76.	Төрийн байгууллагуудын цахим шуудангийн систем шинэчлэгдэж байгаатай холбогдуулан тус яамны албан хэрэгцээнд ашиглаж цахим шуудангийн жагсаалтыг гаргаж Үндэсний дата төвд хүргүүлэв.			√	
77.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.16 дахь хэсэгт заасны дагуу Үндсэн систем болон танилт нэвтрэлтийн системийн гэрээг шинэчлэн байгуулах хүсэлтээ Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлэв.			√	

78.	Засгийн газрын хуралдааны цахим системийг суурилуулах ажлыг 10-р сарын 3-7-ны хооронд Мэдээллийн аюулгүй байдлын газар болон төслийн гүйцэтгэгч АйТиЗон ХХК-ны инженерүүдтэй хамтран гүйцэтгэв.			√	
79.	Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан ажиллах хүчний 2022 оны 3 дугаар улирлын мэдээг Үндэсний статистикийн хороонд хүргүүлэв.			√	

----- оОо -----